



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хашаат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/168-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Open.audit.mn
Архангай аймаг
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор П.Цэцэгдулам
Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1.АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2024.02.19 № 25
танай _____ -ны № _____ -т

ХАШААТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
А.АРИУНБУЯН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хашаат сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хашаат сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Албан хаагчдад нийт 1,148.0 мянган төгрөгийн урамшууллыг холбогдох хууль тогтоомжид заасан хэмжээнээс илүү тооцож олгосон.
2. Цалингийн сангаас албан хаагчдад 6,480.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт олгож төсвийг зориулалт бус зарцуулсан
3. Малжуулах төслөөр олгосон 16,270.0 мянган төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулаагүй.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоол, Сангийн сайдын 190 дүгээр тушаал, "Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэгийн гэрээ" зэргийг зөрчсөн бөгөөд аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 61.4 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 үндсэн зорилтын хүрээнд 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Засаг даргаас 90.1 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	49,231,040.49	92,922,981.39
33	АВЛАГА	0.00	41,270,000.00
33500	Бусад авлага	0.00	41,270,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	41,270,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	49,231,040.49	51,652,981.39
35400	Хангамжийн материал	49,231,040.49	51,652,981.39
35410	Бичиг хэргийн материал	5,273,860.00	3,761,610.00
35420	Аж ахуйн материал	24,489,480.49	31,017,671.39
35440	Түлш, шатах тослох материал	1,944,000.00	2,670,000.00
35450	Барилгын засварын материал	223,700.00	247,700.00
35470	Бусад хангамжийн материал	17,300,000.00	13,956,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,222,489,177.94	1,617,604,439.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,222,489,177.94	1,617,604,439.31
39200	Биет хөрөнгө	1,181,198,177.94	1,575,863,439.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	638,545,466.99	771,707,806.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-104,005,795.48	-100,561,584.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	141,137,550.00	192,937,550.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-80,267,181.62	-101,274,067.54
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	147,683,670.00	204,159,675.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-53,313,695.59	-80,731,039.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,852,164.00	32,852,164.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,556,814.92	-23,203,113.37
39214	Бусад үндсэн хөрөнгө	980,807,777.11	1,239,754,635.11
39215	Хуримтлагдсан элэгдэл	-503,099,462.55	-560,193,085.66
39217	Ном	414,500.00	414,500.00
39300	Биет бус хөрөнгө	41,291,000.00	41,741,000.00
39301	Программ хангамж	6,200,000.00	6,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,975,000.00	-6,125,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	41,066,000.00	41,666,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,271,720,218.43	1,710,527,420.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,271,720,218.43	1,710,527,420.70
51	Засгийн газрын хувь оролцоо	1,271,720,218.43	1,710,527,420.70
51100	Засгийн газрын оруулсан капитал	576,458,170.68	576,458,170.68
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	576,458,170.68	576,458,170.68
51200	Хуримтлагдсан үр дүн	482,276,998.57	921,084,200.84
51210	Өмнөх үеийн үр дүн	290,793,994.88	505,453,498.57
51220	Тайлант үеийн үр дүн	191,483,003.69	415,630,702.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,985,049.18	212,985,049.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,271,720,218.43	1,710,527,420.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	955,560,935.00	1,181,664,508.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	291,925,609.00	411,957,344.00
120	Нийтлэг татварын бус орлого	291,925,609.00	411,957,344.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	880,000.00	2,121,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	880,000.00	2,121,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	291,045,609.00	409,836,344.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	663,635,326.00	769,707,164.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,670,726.00	71,370,064.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	413,200.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,757,526.00	6,087,064.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,500,000.00	65,283,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	647,964,600.00	698,337,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	647,964,600.00	698,337,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	698,625,098.50	766,033,805.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	598,770,028.50	758,326,805.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	471,570,285.36	677,770,193.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,010,285.80	348,285,407.00
210101	Үндсэн цалин	183,234,532.80	245,492,412.00
210102	Нэмэгдэл	29,685,432.00	67,171,954.00
210104	Урамшуулал	7,090,321.00	35,621,041.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,404,225.06	43,293,484.00
210201	Тэтгэврийн даатгал	19,095,171.10	30,052,334.81
210202	Тэтгэмжийн даатгал	2,192,346.71	3,535,568.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,753,877.42	2,793,254.94
210204	Ажилгүйдлийн даатгал	389,112.13	618,777.17
210205	Эрүүл мэндийн даатгал	3,973,717.70	6,293,548.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,049,479.00	16,998,914.20
210301	Гэрэл, цахилгаан	4,513,479.00	8,602,414.20
210302	Түлш, халаалт	9,536,000.00	8,396,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,156,570.30	35,099,868.44
210401	Бичиг хэрэг	5,274,130.00	4,624,350.00
210402	Тээвэр, шатахуун	10,609,625.00	8,892,455.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	925,000.00	1,140,474.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,910,000.00	2,835,580.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,437,815.30	10,985,509.10
210408	Бараа материал акталсны зардал	0.00	6,621,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,682,800.00	3,389,400.00
210604	Урсгал засвар	4,682,800.00	3,389,400.00
2107	Томилолт, зочны зардал	4,830,000.00	13,744,000.00
210702	Дотоод албан томилолт	4,830,000.00	13,744,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,112,048.00	6,663,414.00

Архангай аймгийн Хашаат сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,389,026.00	1,047,564.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	4,474,250.00
210803	Даатгалын үйлчилгээ	558,022.00	376,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	765,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,324,877.20	210,295,705.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,830,250.00	68,972,118.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	150,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	118,994,627.20	141,173,587.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,199,743.14	80,556,612.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,919,300.00	1,524,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,746,800.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,172,500.00	1,524,950.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	110,280,443.14	79,031,662.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,540,943.14	69,935,162.46
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,739,500.00	9,096,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	99,855,070.00	7,707,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	99,855,070.00	7,707,000.00
221001	Их засвар	99,855,070.00	7,707,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	256,935,836.50	415,630,702.54
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	65,452,832.81	0.27
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	3,073,632.81	0.27
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	62,379,200.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	191,483,003.69	415,630,702.27

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	664,515,326.00	730,558,164.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	880,000.00	2,121,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	880,000.00	2,121,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	880,000.00	2,121,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	880,000.00	2,121,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	663,635,326.00	728,437,164.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,670,726.00	30,100,064.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	413,200.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,757,526.00	6,087,064.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,500,000.00	24,013,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	647,964,600.00	698,337,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	647,964,600.00	698,337,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	474,723,056.00	619,575,159.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	474,723,056.00	619,575,159.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,523,312.86	539,018,546.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,010,285.80	348,285,407.00
210101	Үндсэн цалин	183,234,532.80	245,492,412.00
210102	Нэмэгдэл	29,685,432.00	67,171,954.00
210104	Урамшуулал	7,090,321.00	35,621,041.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,404,225.06	43,293,484.00
210201	Тэтгэврийн даатгал	19,095,171.10	30,052,334.81
210202	Тэтгэмжийн даатгал	2,192,346.71	3,535,568.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,753,877.42	2,793,254.93
210204	Ажилгүйдлийн даатгал	389,112.13	618,777.17
210205	Эрүүл мэндийн даатгал	3,973,717.70	6,293,548.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,898,479.00	17,724,914.20
210301	Гэрэл, цахилгаан	4,513,479.00	8,602,414.20
210302	Түлш, халаалт	10,385,000.00	9,122,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,260,650.00	18,940,009.34
210401	Бичиг хэрэг	3,249,600.00	3,007,100.00
210402	Тээвэр, шатахуун	10,547,050.00	8,624,055.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	925,000.00	1,140,474.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,910,000.00	3,288,580.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,629,000.00	2,879,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,452,000.00	3,423,800.00
210604	Урсгал засвар	3,452,000.00	3,423,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,830,000.00	13,744,000.00
210702	Дотоод албан томилолт	4,830,000.00	13,744,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,112,048.00	6,663,414.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,389,026.00	1,047,564.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	4,474,250.00
210803	Даатгалын үйлчилгээ	558,022.00	376,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	765,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,555,625.00	86,943,518.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,055,625.00	86,793,518.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,199,743.14	80,556,612.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,919,300.00	1,524,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,746,800.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,172,500.00	1,524,950.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	110,280,443.14	79,031,662.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,540,943.14	69,935,162.46
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,739,500.00	9,096,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	189,792,270.00	110,983,005.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	189,792,270.00	110,983,005.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	189,792,270.00	110,983,005.00
2200	Дотоод эх үүсвэрээр	189,792,270.00	110,983,005.00
220001	Барилга байгууламж	20,000,000.00	0.00
221001	Их засвар	99,855,070.00	7,707,000.00
222001	Тоног төхөөрөмж	42,379,200.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,558,000.00	103,276,005.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-189,792,270.00	-110,983,005.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	290,793,994.88	1,080,237,214.74
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	290,793,994.88	1,080,237,214.74
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	191,483,003.69	191,483,003.69
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	482,276,998.57	1,271,720,218.43
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	482,276,998.57	1,271,720,218.43
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	23,176,500.00	23,176,500.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	505,453,498.57	1,294,896,718.43
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	415,630,702.27	415,630,702.27
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	921,084,200.84	1,710,527,420.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	698,497,100.00	630,522,937.54	67,974,162.46	90.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	576,635,600.00	519,539,932.54	57,095,667.46	90.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	573,635,600.00	518,014,982.54	55,620,617.46	90.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,884,000.00	348,285,407.00	34,598,593.00	90.96
210101	Үндсэн цалин	382,884,000.00	245,492,412.00	137,391,588.00	64.12
210102	Нэмэгдэл	0.00	67,171,954.00	-67,171,954.00	-
210104	Урамшуулал	0.00	35,621,041.00	-35,621,041.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,860,500.00	43,293,484.00	4,567,016.00	90.46
210201	Тэтгэврийн даатгал	32,545,100.00	30,052,334.81	2,492,765.19	92.34
210202	Тэтгэмжийн даатгал	3,828,800.00	3,535,568.76	293,231.24	92.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,063,100.00	2,793,254.93	269,845.07	91.19
210204	Ажилгүйдлийн даатгал	765,800.00	618,777.17	147,022.83	80.80
210205	Эрүүл мэндийн даатгал	7,657,700.00	6,293,548.33	1,364,151.67	82.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,550,000.00	17,724,914.20	825,085.80	95.55
210301	Гэрэл, цахилгаан	6,350,000.00	8,602,414.20	-2,252,414.20	135.47
210302	Түлш, халаалт	12,050,000.00	9,122,500.00	2,927,500.00	75.71
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	0.00	150,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	21,661,100.00	18,940,009.34	2,721,090.66	87.44
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	3,007,100.00	-7,100.00	100.24
210402	Тээвэр, шатахуун	10,500,000.00	8,624,055.00	1,875,945.00	82.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	1,140,474.34	-240,474.34	126.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,409,600.00	3,288,580.00	1,121,020.00	74.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,851,500.00	2,879,800.00	-28,300.00	100.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,425,900.00	3,423,800.00	2,100.00	99.94
210604	Урсгал засвар	3,425,900.00	3,423,800.00	2,100.00	99.94
2107	Томилолт, зочны зардал	14,554,100.00	13,744,000.00	810,100.00	94.43

Архангай аймгийн Хашаат сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	14,554,100.00	13,744,000.00	810,100.00	94.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,700,000.00	5,615,850.00	1,084,150.00	83.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,400.00	0.00	123,400.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,400,000.00	4,474,250.00	925,750.00	82.86
210803	Даатгалын үйлчилгээ	376,600.00	376,600.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	765,000.00	35,000.00	95.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,000,000.00	66,987,518.00	11,012,482.00	85.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,500,000.00	66,837,518.00	10,662,482.00	86.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	150,000.00	350,000.00	30.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	1,524,950.00	1,475,050.00	50.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	1,524,950.00	1,475,050.00	50.83
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	1,524,950.00	1,475,050.00	50.83
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	121,861,500.00	110,983,005.00	10,878,495.00	91.07
221001	Их засвар	32,000,000.00	26,707,000.00	5,293,000.00	83.46
222001	Тоног төхөөрөмж	89,861,500.00	84,276,005.00	5,585,495.00	93.78
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	698,497,100.00	630,522,937.54	67,974,162.46	90.27
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	505,117,800.00	628,401,937.54	123,284,137.54	124.41
320001	Орон нутгийн төсвөөс	505,117,800.00	628,401,937.54	123,284,137.54	124.41
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	193,379,300.00	2,121,000.00	191,258,300.00	1.10
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	160,000.00	2,121,000.00	-1,961,000.00	1,325.63
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	193,219,300.00	0.00	193,219,300.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	19.00	4.00	82.61
620001	Удирдах ажилтан	8.00	7.00	1.00	87.50
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	6.00	3.00	66.67
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23.00	19.00	4.00	82.61
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	4.00	5.00	44.44

Архангай аймгийн Хашаат сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	9.00	-3.00	150.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	6.00	2.00	75.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,003,564.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,003,564.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,003,564.00
2104	Хангамж, бараа материалын зардал	
210401	Бичиг хэрэг	
210402	Тээвэр, шатахуун	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,047,564.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,047,564.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,956,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,956,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,003,564.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,100,064.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,087,064.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,013,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Авлагын үлдэгдлийг гэрээт хугацаанд нь барагдуулсан эсэхийг авч үзэх болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 51,948.5 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа.

Залруулсан алдаа:

- Өвс тэжээл борлуулсны орлого 10,678.5 мянган төгрөг, малжуулахын зээлийн үлдэгдэл нийт 41,270.0 мянган төгрөгийн авлагыг тайлан балансад авлагаар тусгаагүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 358,178.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 357,030.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 1,148.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

Аудитаар залруулагдаагүй материаллаг 3 зөрчилтэй асуудал нь 23,898.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 10,477.4 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Сумын багийн Засаг дарга нарын үр дүнг үнэлэн 1,148.0 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 "Төрийн албан тушаалыг доор дурдсанаар ангилна", 10.3. "Энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал гэнэ", тус хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж дүгнэнэ", Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтын 2.4. "Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална", Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Цалингийн сангаас албан хаагчдад 6,480.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт олгож төсвийг зориулалт бус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 190 дүгээр тушаалын 210104 "Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу ажлын үр дүнг сар, улирал, жилээр үнэлэн олгох мөнгөн урамшуулал ...гэх мэт зардлыг энд бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах албан шаардлага хүргүүллээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.2 Малжуулах төслөөр олгосон зээлийн 16,270.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй хугацаа хэтрүүлсэн байна.

Энэ нь "Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэгийн гэрээ"-ний 1.2, 2.6, 2.7 дахь заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 104 нэр төрлийн 266,552.5 мянган төгрөгийн хөрөнгө тайлант жилд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөж ашиглалтын хугацаа дууссан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл "Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах" 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 Тоног төхөөрөмж дансанд 12 нэр төрлийн 87 ширхэг 21,125.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 36 нэр төрлийн 175 ширхэг 38,271.9 мянган төгрөгийн бараа материал, 4 нэр төрлийн 54 ширхэг 8,330.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт **67,727.5** мянган төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.3. "Энэ журмын 4.1.1-д заасан хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж хөрөнгө, материалыг зөв ангилж бүртгэн биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Авлагыг тайланд тусгаагүй орхигдуулсан	1	41270.0	1	41270.0			1	41270.0			-	
Орлогыг үр дүнгийн тайланд тусгаагүй орхигдуулсан	1	10678.5	1	10678.5			1	10678.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Багийн засаг даргарт үр дүнгийн урамшуулал олгосон	1	1148.0	1	1148.0								
Түлээ, нүүрсний хөнгөлөлт цалингийн сангаас олгосон	1	6480.0			1	6480.0						
Хугацаа хэтэрсэн авлагатай	1	16270.0			1	16270.0						
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн	1	266552.5			1	266552.5						
Үндсэн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн	1	67727.5			1	67727.5						
Нийт дүн	5	358,178.0			4	357,030.0						